

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

- а. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.**
б. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

- Дунд палеолитын үед гарсан дэвшил аль нь вэ? (1 оноо)
 А. Гал В. Эхийн эрхт овог
 С. Хэл яриа D. Үйлдвэрлэх аж ахуй E. Хүрэл зэвсэг
- Дунд палеолитын үед багаж зэвсэгт ямар дэвшил гарсан бэ? (2 оноо)
 А. Модны уян харимхай чанарыг ашиглан нум сум зохион бүтээсэн.
 В. Зэсийг хорголжин тугалгатай хольж хүрэл боловсруулж эхэлсэн.
 С. Үзүүр мэсийг ишинд бэхэлж жад хийх болсон.
 D. Үлдэц, цуулдас гаргах аргаар чулуун зэвсэг хийх болсон.
 E. Шавар ваар, сав хийж хэрэглэх болсон.
- 3000 гаруй сувс, хүний нүүр сийлсэн чулуун онго, чулуун ир шигтгэсэн ясан хутга, амьтны шүд хэлхсэн хүзүүний зүүлт, ясан бугуйвч зэрэг гоёлын зүйлс болон чулуун зэвсгүүд дагалдуулсан неолитын үеийн булш хаанаас олдсон бэ? (1 оноо)
 А. Ховд аймгийн Манхан сумын Хойд цэнхэрийн агуй
 В. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам
 С. Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул
 D. Дорнод аймгийн Булган сумын Норовлин
 E. Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй
- Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 Монгол орны төв, баруун хэсэгт өргөн тархсан хүрэл, түрүү төмрийн үеийн тахилга ба оршуулгын байгууламжийг гэнэ. (1 оноо)
 А. Хадны зураг В. Буган хөшөө
 С. Хиргисүүр D. Дөрвөлжин булш E. Шоргоолжин булш
- Хүрлийн үе, түрүү төмрийн үеэс цэргийн удирдагчдын гарт эрх мэдэл очив. Цэргийн удирдагчдад эрх мэдэл төвлөрөх болсон шалтгааныг тодорхойлно уу. (1 оноо)
 А. Торгоны замд нөлөөллөө тогтоох өрсөлдөөн нэмэгдсэн.
 В. Галыг эзэмшсэн нь цэргийн удирдагчдад давуу байдлыг үүсгэсэн.
 С. Нум сум зохион бүтээснээр эрчүүд илүү эрх мэдэлтэй болсон.
 D. Овог аймгуудын хооронд зөрчил тэмцэл гарах болсноор цэргийн үүрэг нэмэгдсэн.
 E. Овог дотор өмч хөрөнгийн ялгаа бий болсноор тэдний зарим хэсэг нь эрх мэдэлтэй болсон.
- Хүннү гүрний шаньюй нарыг төр барьсан онтой нь зөв харгалзуулна уу. (1 оноо)
 1. Модунь шаньюй a. НТӨ 161-126 он
 2. Гүнчин шаньюй b. НТӨ 209-174 он
 3. Гиюй (Лаошан) шаньюй c. НТӨ 174-161 он
 А. 1a2b3c В. 1b2a3c C. 1c2a3b D. 1b2c3a E. 1c2b3a
- Даюанаас баруун тийш 3000 ли /1500км/ газар Гүй голын хойно Их Юэжи нар амьдардаг. 1 ли хэдэн км-тэй тэнцэх вэ? (2 оноо)
 А. 1500 км В. 0.5 км C. 4500 км D. 2 км E. 0.05 км
- Сяньби угсааны улсыг олно уу. (1 оноо)
 А. Цинь улс В. Хань улс
 С. Түрэг улс D. Уйгур улс E. Тоба Вэй улс



9. “Их ахлагч нум сум, эмээл хазаар хийж чаддаг, алт, төмөр хайлдаг, цэргийн зэвсэг хийдэг, арьс боловсруулдаг...” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар аж ахуйн талаар өгүүлж байна вэ? (1 оноо)

- A. Худалдаа, арилжаа B. Газар тариалан
C. Мал аж ахуй D. Ан гөрөө E. Гар урлал

10. “Хүннүгийн хүн ам Хань улсын нэг тойрогт хүрэхгүй. Хүчирхэг байгаагийн шалтгаан нь хувцас хунар, хоол, идээ өөр. Хань (Хятад)-д түшиглэхгүйн учир болой” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санаа илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Хүннү улс нийгэм, соёлын хувьд бие даасан хүчирхэг улс байсан.
B. Хань улсын хүн ам Хүннүгээс олон байсан учир хүчирхэг байсан.
C. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.
D. Хүннү улс Хань улсад түшиглэдэг байсан учир хүчирхэг байсан.
E. Хүннү нар Хань улсын хүн амаас цөөн байсан учир хүчирхэг биш байсан.

11. Хятан гүрний хаад ямар шашныг тэтгэж байсан бэ? (1 оноо)

- A. Бурхны шашин B. Бөөгийн шашин
C. Исламын шашин D. Загалмайн шашин E. Манихейн шашин

12. Төв аймгийн Борнуур сумын Ноён уулын язгууртны булшнаас Грек домгийн бурхад дүрсэлсэн мөнгөн эдлэл олдсон нь юуг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Модунь шаньюй Грект айлчилж байсан
B. Грекчүүд, Хүннү гүрэнд жил бүр алба барьдаг байсан
C. Хүннү гүрэн, Гректэй хиллэдэг байсан
D. Хүннү гүрэн, Гректэй байлдаж байсан
E. Хүннү гүрэн өрнийн орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаатай байсан

13. Монголын Хэрэйд, Найман зэрэг улсууд нь ямар шашин шүтэж байсан бэ? (1 оноо)

- A. Буддын шашин B. Бөөгийн шашин
C. Исламын шашин D. Загалмайн шашин E. Манихейн шашин

14. 1135 онд Хабул хан Алтан улсад айлчилжээ. Энэ үйл явдал хэддүгээр зуунд хамаарахыг тооцоолно уу. (2 оноо)

- A. XI зууны I хагас B. XII зууны II хагас
C. XII зууны I хагас D. XI зууны II хагас E. X зууны I хагас

15. “Татар хүний бие бялдар өндөр бус, хамгийн өндөр нь таван тохой хоёр ямхаас давахгүй” гэсэн сурвалжийн мэдээг ашиглан татар хүний өндрийг тооцоолон олно уу. /нэг тохой 35 см орчим, ямх-3.2 см/ (2 оноо)

- A. 171.4 см B. 175 см C. 156.4 см D. 181.4 см E. 176.4 см

16. Их Монгол улс нэгэн зэрэг хоёр хаантай байсан үеийг олно уу. (1 оноо)

- A. 1246-1248 он B. 1241-1246 он
C. 1260-1264 он D. 1251-1259 он E. 1229-1241 он

17. Юань улс хүн амаа дөрвөн зэрэгт хуваажээ. Монгол хүн хэддүгээр зэрэгт хамаарах вэ? (1 оноо)

- A. Тэргүүн B. Дэд C. Гуравдугаар D. Дөрөвдүгээр E. Тавдугаар



18. Алтан орд улсын газар нутгийг зөв тодорхойлно уу. (1 оноо)
 А. Өнөөгийн Иран, Ирак, Солонгос, Хятадын нутаг
 В. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу Хуучин Хар Хятаны нутаг
 С. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Сирийн хойд хэсэг Афганистаны баруун хэсэг
 D. Монгол, Төвөд, Солонгос, Хятадын нутаг
 E. Дорно зүг Эрчис мөрөн, өрнө зүгт Дунай мөрний доод урсгал, өмнө зүгт Кавказын нуруу, хойд зүгт Ижил мөрөн хүртэл
19. Даалгаврыг гүйцэтгэхдээ дараах томъёог ашиглаарай. (X=M-M/33+622)
 Хижрийн 719 онд Бухар хотод цутгасан зоосны нүүрэн талд “Кебек хаан” ар талд “Цагадай хааны тамга” сийлжээ. Хижрийн тооллын 719 оныг аргын тоололд шилжүүлнэ үү. (2 оноо)
 А. 1341 он В. 64 он С. 1374 он D. 1320 он E. 655 он
20. Аюушридар хааны төр барьсан он аль нь вэ? (1 оноо)
 А. 1393-1399 он В. 1378-1388 он
 С. 1370-1378 он D. 1400-1402 он E. 1403-1412 он
21. Улс төрийн бутралын үеийн Зүүн Монголын баруун гарын гурван түмнийг зөв ялгасныг олно уу. (2 оноо)
 1. Ордос 2. Халх 3. Урианхай 4. Түмэд 5. Юншээбүү 6. Цахар
 А. 2,3,6 В. 1,4,5 С. 2,4,5 D. 1,2,3 E. 1,3,6
22. Мин улс Монгол улстай худалдаа хийхдээ зөвхөн нас залуу агт морьд, үржлийн насны гүүгээр арилжаа хийдэг байжээ. Энэ нь ямар зорилготой байсан бэ? (2 оноо)
 А. Газар тариалангийн салбарт адууны хүчийг ихээр ашиглах
 В. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулах, адуун сүргийн бүтцийг алдагдуулах
 С. Худалдааны салбарт адуу ашиглан бараа таваар тээвэрлэх
 D. Мин улс барууны улс орнуудтай адуугаар худалдаа хийх
 E. Монголчуудад адуугаараа хятад бараа худалдан авах нь ашигтай байсан.
23. Зүүнгарын хаант улсыг байгуулсан түүхэн зүтгэлтэн аль нь вэ? (1 оноо)
 А. Цэвээнравдан хаан В. Гүүш хан Төрбайх
 С. Галдан хаан D. Галданцэрэн хаан E. Даваач хаан
24. Соёмбо үсгийг хэн зохиосон бэ? (1 оноо)
 А. Зая бандида Намхайжамц В. Өндөр гэгээн Занабазар
 С. Аюуш гүүш D. Пагва лам E. Агваан лам
25. Түмэдийн Алтан ханы шашны цааз ёсоор лам нарт юуг хориглож байсан бэ? (2 оноо)
 А. Сарын гурван бацгийн (мацаг) өдөр мацаг барихыг хориглоно.
 В. Сүм, хийдэд ерөөл, хурал майдар эргэхийг хориглоно.
 С. Тойн лам нар гэргий авахыг хориглоно.
 D. Төвөд хэл бичиг сурахыг хориглоно.
 E. Хүрээ хийдэд шавилан суухыг хориглоно.



26. Монголд бурхны шашин дэлгэрэхэд нөлөөлсөн дотоод хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Монголын эрх баригчид улс орныхоо нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх зорилгодоо шашныг ашиглаж байжээ.
 В. XVI зууны сүүл үеэс бурхны шашны шар, улааны урсгалууд өөрсдийн нөлөөг дэлгэрүүлэхээр өрсөлдөх болжээ.
 С. Төвөд улсын шашны урсгалууд монголчуудаас цэрэг, эдийн засгийн дэмжлэг хайж байжээ.
 D. Төвөд, Мин улсын түрэмгийллээс өөрсдийгөө хамгаалахын тулд гаднаас цэрэг, эдийн засгийн тусламж хайж байжээ.
 E. Монголын мал сүрэг, алт мөнгө нь Төвөдийн шар, улааны урсгалуудад томоохон дэмжлэг болжээ.
27. Халх Монгол Манжид хэзээ дагаар орсон бэ? (1 оноо)
 А. 1688 он В. 1636 он С. 1721 он D. 1755 он E. 1691 он
28. 1689 оны Ар элстэйн чуулганаар Халхын ноёд ямар асуудлыг хэлэлцсэн бэ? (2 оноо)
 А. Халхын ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцсэн.
 В. Өвөр Монголын 16 аймгийн ноёд Манжид дагаар орох асуудлыг хэлэлцсэн.
 С. Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг Халхын шарын шашны тэргүүнээр өргөмжлөх асуудлыг хэлэлцсэн.
 D. "Монгол-Ойрадын Их цааз" -ыг батлах асуудлыг хэлэлцсэн
 E. Торгуудын Хо өрлөг, Дөрвөдийн Далай тайш нар харьяатаа авч баруун тийш нүүдлэх асуудлыг хэлэлцсэн.
29. 1630-аад оны дундуур Ижил мөрний доод хэсэгт нутаглах болсон Монголчуудыг хожим юу гэж нэрлэх болсон бэ? (1 оноо)
 А. Аварууд В. Буриад Монгол
 С. Өвөр Монгол D. Хазар E. Халимаг
30. Лигдэн хаан 1617 онд Авга хар ууланд ямар нэртэй хотыг байгуулсан бэ? (1 оноо)
 А. Хархорум хот В. Хөх хот
 С. Шар бөсийн орд D. Очир Цагаан хот E. Байшин хот
31. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгааныг олно уу. (2 оноо)
 А. Зүүнгар улс болон Халх Монгол хоорондоо эв түнжингүй байсан.
 В. Халхын баруун, зүүн гар хоорондоо дайсагнасан байдалтай байсан.
 С. Манж нар хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлого явуулсан.
 D. Монголчууд Мин улстай худалдаа арилжаа хийж байсан.
 E. Монголын их хааны засаглал суларсан.
32. Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү.
 1905 оны намар Өвөр монголын Жирмийн чуулганы өмнөд Горлос хошуунд
 удирдлагаар зэвсэгт бослого гарчээ. (1 оноо)
 А. Цогдалай В. Тогтох тайж
 С. Чингүнжав D. Онолт E. Энхтайван
33. Өвөр Монголд XIX зууны дунд үеэс манжийн эсрэг бослого тэмцэл удаа дараа гарах болсон шалтгаан аль нь вэ? (2 оноо)
 А. 1758 оны эцэс хүртэл Зүүнгарын босогчид хэсэг бүлгээр тулалдсанаас болсон
 В. Шинэ засгийн бодлого хэрэгжиж эхэлсэн.
 C. 1756 онд Чин ван Эринчиндоржийг Амарсанаагийн хэрэгт холбогдуулан цаазаар авснаас болсон.
 D. Хятадын мөнгө хүүлэгч, худалдаачдын мөлжлөг, хятад иргэд нутаг бэлчээр булаан тариа тарин суурьших болсон.
 E. Халх Монголчуудаас авах манжийн алба нэмэгдсэнээс болсон.



34. Манж амбан Сандо Хүрээнээс хэзээ хөөгдөн гарсан бэ? (1 оноо)
 A. 1911.12.04 B. 1911.11.30
 C. 1911.12.01 D. 1911.12.29 E. 1911.12.03
35. Монголчууд Ховдыг Манжийн эрхшээлээс хэзээ чөлөөлсөн бэ? (1 оноо)
 A. 1912.2 сард B. 1912.1 сард
 C. 1912.8 сард D. 1914.2 сард E. 1915.6 сард
36. Богд Хаант Монгол улсын анхны иргэний сургууль хэзээ байгуулагдсан бэ? (1 оноо)
 A. 1918 он B. 1913 он C. 1914 он D. 1915 он E. 1912 он
37. 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол Улсын шаштир” хэмээх түүхийн бүтээл гарчээ. Энэ нь Олноо өргөгдсөний хэддүгээр он бэ? (2 оноо)
 A. 18 дугаар он B. 7 дугаар он
 C. 9 дугаар он D. 8 дугаар он E. 19 дугаар он
38. Богдын тэргүүлсэн засгийн газрын үйл ажиллагаанд аль нь хамаарах вэ? (2 оноо)
 A. Ардын журамт цэргийг өргөтгөх хүч нөлөөгөө нэмэгдүүлэх
 B. МАН, Түр засгийн төлөөний түшмэлийг хошуу, шавьд томилон суулгахаар шийдсэн
 C. АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байсан
 D. Цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах
 E. Цагаантны цэргийг хөөн зайлуулах тулд улаан цэргийн ангийг Монголд оруулах хүсэлтийг ЗОУ-д тавьсан
39. Монгол улсын хөгжлийн талаарх С.Данзангийн үзэл баримтлал аль нь вэ? (1 оноо)
 A. Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тухайн цаг үед тохиромжтой
 B. Монголд бүгд найрамдах засаг тогтоох, хүн төрөлхтний туулж ирсэн жам ёсны хөгжлийн дагуу, шат дараалан хөгжих ёстой.
 C. Уламжлал, шинэчлэлийг хослуулах, ардчилсан чиг шугамыг баримтлах
 D. Монгол улс социалист чиг баримжаагаар хөгжих
 E. Уламжлалт хэмжээгүй эрхт хаант засаглалтай байх
40. Ардын засгийн газраас гадаад байдлаа бэхжүүлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аль нь вэ? (2 оноо)
 A. “Улсын түр цагийн хурал”-ыг байгуулсан
 B. “Тангарагийн гэрээ”-г батлан мөрдүүлсэн
 C. Эзэн, хамжлагын харилцааг халах шийдвэр гаргасан
 D. С.Данзан тэргүүтэй монголын төлөөлөгчид Москвад айлчилсан
 E. Судар бичгийн хүрээлэн байгуулсан
41. Монгол улс бүгд найрамдах засаглалд хэзээ шилжсэн бэ? (1 оноо)
 A. 1992.01.13 B. 1924.06.07
 C. 1940.06.30 D. 1990.07.29 E. 1924.11.26
42. Анхдугаар Үндсэн хуулиар улс төрийн эрхээ хасуулаагүй хүмүүс аль нь вэ? (1 оноо)
 A. Жинхэнэ ард B. Бусдыг хөлслөн аж ахуй эрхлэгчид
 C. Хутагт хувилгаад D. Урьдын ван, гүн E. Ял шийтгэгдэгсэд



43. Шинэ эргэлтийн бодлогын үр дүн аль нь вэ? (2 оноо)
 А. Нөхөрлөл, коммуна, артель нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зуугаар нь байгуулсан.
 В. Ард иргэд хэвийн аж төрөх боломжгүй болсноос нутгаа орхин хил даван нүүж эхэлсэн.
 С. Мал сүргийг өсгөх уян хатан бодлогын үр дүнд ганцхан жилийн дотор малын тоо 3.3 саяар өссөн.
 D. Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгон хувийн худалдааг хавчих болсон.
 E. Улс орныг удирдах хэрэгт намын үүрэг нэмэгдсэн.
44. Европт энх амгалан байдал ямар үйл явдлаар тогтсон бэ? (1 оноо)
 А. 1945 оны 9 сарын 2-нд Япон үг дуугүй бууж өгөх актад гарын үсэг зурсан
 В. 1945 оны 5 сарын 9-нд Нацист Герман бууж өгсөн
 С. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ Японд дайн зарласан
 D. 1945 оны 8 сарын 10-нд БНМАУ Японд дайн зарласан
 E. 1945 оны 2 сард Ялтад гурван их гүрний уулзалт болсон
45. Атрын анхдугаар аян хэдэн оноос эхэлсэн бэ? (1 оноо)
 А. 2008 он В. 1976 он С. 1959 он D. 1981 он E. 1961 он
46. Шинжлэх ухаан, техникийн хөгжилд аль нь хамаарах вэ? (1 оноо)
 А. 1988 онд “Мандухай сэцэн хатан” кино дэлгэцнээ гарсан
 В. Сургуулийн бүтцийг 3+5+2 болгон өөрчилсөн
 С. 1970 он гэхэд хүн амын 89,3% нь бичиг үсэг тайлагдсан
 D. Монголын эрдэмтэд сансар судлалын “Интеркосмос” программыг хэрэгжүүлэх ажилд гар бие оролцсон
 E. 1968 оны Мехикогийн олимпын тоглолтоос 1 алт, 3 хүрэл медаль хүртсэн
47. БНМАУ 1972 онд Япон улстай дипломат харилцаа тогтоосон. Энэ жил дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой вэ? (2 оноо)
 А. 57 жилийн ой В. 59 жилийн ой
 С. 51 жилийн ой D. 61 жилийн ой E. 50 жилийн ой
48. Социалист системийн бүрэлдэхүүнд багтаж байсан улс аль нь вэ? (2 оноо)
 А. Зүүн Герман В. Баруун Герман
 С. Их Британи D. Франц E. Дани
49. Монголын ардчилсан холбооны анхны улс төрийн цуглаан хэзээ болсон бэ? (1 оноо)
 А. 1990.02.18 В. 1989.12.07
 С. 1990.01.21 D. 1989.12.10 E. 1990.03.07
50. Аль түүхэн үйл явдлаар БНМАУ-д олон намын тогтолцоо бий болох эхлэл тавигдсан бэ? (2 оноо)
 А. 1990 оны 3 сарын 9-ний орой нам, төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио, телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
 В. 1990 оны 3 сарын 12-14 нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо, нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
 С. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийн заалтыг хүчингүй болгосноор
 D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
 E. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар



51. Монгол улс 1992 онд шинэ Үндсэн хуулийг баталснаар ямар засаглалтай болсон бэ?

(1 оноо)

- A. Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай болсон
- B. Парламентын бүгд найрамдах засаглалтай болсон
- C. Хэмжээгүй эрхт хаант засаглалтай болсон
- D. Хэмжээт эрхт хаант засаглалтай болсон
- E. Холимог бүгд найрамдах засаглалтай болсон

52. Шинэ үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдлийг төрийн ямар институт хэрэгжүүлэх болсон бэ?

(1 оноо)

- A. УБХ-ын тэргүүлэгчид
- B. Улсын бага хурал
- C. Улсын хурал
- D. Улсын их хурал
- E. Ардын их хурал

53. 2012 оноос өвлийн тэргүүн сарын шинийн нэгний өдрийг ямар тэмдэглэлт баярын өдөр болгосон бэ?

(1 оноо)

- A. Хэвлэлийн эрх чөлөөний өдөр
- B. Эх орончдын өдөр
- C. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр
- D. Монгол бахархлын өдөр
- E. Олон улсын хүний эрхийн өдөр

54. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг илэрхийлэх баримт аль нь вэ?

(2 оноо)

- A. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.
- B. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль” баталсан.
- C. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
- D. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
- E. 1990 онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн.

55. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улсуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх нь ямар бодлого вэ?

(1 оноо)

- A. “Гуравдагч хөрш”-ийн бодлого
- B. Зөөлөн хүчний бодлого
- C. Социалист улсуудтай хамтын ажиллагаа гүнзгийрүүлэх бодлого
- D. Олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцах бодлого
- E. Европын улсуудтай харилцаагаа өргөжүүлэх бодлого

56. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү

Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь-ыг хангах үндэс билээ.

(1 оноо)

- A. Эдийн засгийн аюулгүй байдал
- B. Дотоод аюулгүй байдал
- C. Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал
- D. Мэдээллийн аюулгүй байдал
- E. Хүний аюулгүй байдал



ХОЁРДУГААР ХЭСЭГ**Санамж:**

- а. Даалгаврын хариуг зөв тогтоож харгалзуулах, дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.**
б. Зөв хариулт бүр нэг оноотой.

2.1. Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлт болон дурсгалуудыг хамрах үетэй нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------------|---------------------------------|
| а. Жад | 1. Дунд палеолит |
| б. Амьтныг анх гаршуулсан | 2. Хүрлийн үе, түрүү төмрийн үе |
| с. Овог үүссэн | 3. Мезолит |
| д. Үйлдвэрлэх аж ахуй | 4. Дээд палеолит |
| е. Цагаан агуй | 5. Неолит |
| ф. Дөрвөлжин булш | 6. Доод палеолит |

2.2. Чингис хаантай холбогдох үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|--|------------|
| а. Тэмүжин Мэргидийн довтолгоонд өртөж, Бөртийг алдав. | 1. 1189 он |
| б. Хар зүрхний Хөх нуурт Монгол улсын хаанд өргөмжлөв. | 2. 1203 он |
| с. Далан балжудад болсон байлдаанд Чингис хаан ялагдав. | 3. 1190 он |
| д. Улз голд Татар аймгийг бут цохив. | 4. 1196 он |
| е. Хүйтэн хэмээх газарт Гүр хан Жамухын цэргийг бут цохив. | 5. 1201 он |
| ф. Чингис хаан Хэрэйд улсыг мөхөөв. | 6. 1179 он |

2.3. Түүхэн нэр томьёонуудыг зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|----------------------|----------------|
| а. Халх Монгол | 1. Энх-Амгалан |
| б. Өвөр Монгол | 2. Шолой Уваш |
| с. Өврийн таван отог | 3. Цахар |
| д. Манж | 4. Торгууд |
| е. Дөрвөн Ойрад | 5. Түшээт хан |
| ф. Хотгойд | 6. Алчуболд |

2.4. Түүхэн үйл явдлын он цагийг тохируулахдаа 1-8 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. /2 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/ (6 оноо)

- | | |
|--|-------------------------|
| а. Барон Унгерн Нийслэл хүрээг чөлөөлөв. | 1. 1921 оны 3 сарын 1-3 |
| б. Ардын түр засгийн байгуулагдав. | 2. 1921 оны 2 сарын 4 |
| с. Хиагтийг чөлөөлөв. | 3. 1921 оны 2-р сард |
| д. Богдыг хэмжээт эрхт хаанаар өргөмжлөв. | 4. 1921 оны 3 сарын 18 |
| е. МАН байгуулагдав. | 5. 1921 оны 3 сарын 13 |
| ф. Д.Сүхбаатарыг цэргийн жанжнаар томилов. | 6. 1921 оны 3 сарын 17 |
| | 7. 1921 оны 7 сарын 11 |
| | 8. 1921 оны 7 сарын 8 |

